ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ
Нутгийн удирдлагын ордон. С.Буяннэмэхийн өргөн чөлөө,
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592128, 70593936
Цахим хуудас: www.dundgovi.khural.mn
Цахим хаяг: dundgovi.khural@gmail.com

2021.01.03 № 2/01

танай ____________ -ны № ____________ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.МӨНХБАТ ТАНАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" 14 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэсэн байна.

Тогтоолыг хүргүүлж байна.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЭНХСҮХ

4801220 1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2021.12.27 № 1/5573

танай ____________-ны №____________-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
С.ОД-ЭРДЭНЭ ТАНАА

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" 14 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ..5611.... дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.

Х.НЯМБААТАР

15130563

А5 Файл.2021

2021 12 27
5611

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 03 өдөр　　Дугаар 14　　Мандалговь

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1.2 д, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймаг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан хавсралтад заасан хувь хэмжээгээр тогтоосугай.

Хоёр. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тогтоосон хэмжээгээр авч орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлж, ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай

ГуравҮл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тогтоосон хэмжээг Хууль зүй Дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж хэрэгжүүлсүгэй.

Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 03 дугаар тогтоолыг энэхүү тогтоол мөрдөж эхэлсэн өдрөөс хойш хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА　　С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн
14 дүгээр тогтоолын хавсралт

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээ

| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч | Албан татварын хувь хэмжээ |
|---|---|
| Уул уурхайн компаниуд болон тээвэрлэгч, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд | 1.0% |
| Бусад аж ахуй нэгж, иргэн | 0.8% |